Эрчимт эмчилгээний сувилагчийн ажлын ачааллыг судалсан дүн

М.Мөнх-Эрдэнэ[1], Б.Оюундарь[1], П.Тунгалаг[1]

[1]Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасаг, УХТЭ
Цахим хаяг: muugiimmuugim@gmail.com, Утас: 88743245

Түлхүүр үг:

Эрчимт эмчилгээ
Сувилахуй
Ажлын байрны стресс

Товч утга: Ажлын хэт ачаалал нь ажил үүргийн тодорхой бус байдал, ажилчид хоорондын харилцааны зөрчил, цалин урамшуулалтай холбоотой асуудал удаан хугацаанд үргэлжилсэний улмаас ажлаас халшрах хам шинж үүсдэг. Мөн ажлын бүтээмж буурах, шалтгаангүй ажлаа таслах, ажилдаа сэтгэл ханамжгүй болох, өөрт итгэх итгэлээ алдах зэрэг шинжүүд илэрдэг. Судалгааны мэдээ мэдээллийг цуглуулахдаа нэг агшингийн судалгааны загвараар тоон судалгааны аргыг ашиглан Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасгийн 17 сувилагчийг хамруулан ажлын ачааллыг тодорхойлж, судалгааны үр дүнгийн боловсруулалтыг SPSS-21 програм ашиглан дүн шинжилгээ хийсэн.

Үндэслэл: 1850 онд Флоренс Найтингейль хамгийн хүнд өвчтэй хүмүүсийг сувилагчийн хяналтанд ойрхон байлгаж илүү ойроос хянаж эхэлсэн ба хожим 1923 онд Валтер И Данди эмч мэдрэлийн хагалгааны дараа хүнд өвчтөнийг хянах 3 ортой тасаг нээж өвчтөнүүдийг тусгай бэлтгэгдсэн сувилагч хянаж эхэлснээр одоогийн эрчимт эмчилгээний тасгийн суурь тавигдсан түүхтэй. Амин чухал эрхтэн системийн үйл ажиллагааны гүн хямралд орсон хүнд өвчтөнүүдийг нэг дор төвлөрүүлэн, аппарат тоног төхөөрөмж, шинжилгээний нарийн аргуудын тусламжтай, чадварлаг баг хамт олноороо нэгдэн, оношийг богино хугацаанд тогтоож, цаг алдалгүй эрчимтэйгээр эмчилж, сувилах нь эрчимт эмчилгээний тасгийн гол зорилго билээ.

Иймд сувилагчийн ажлын ачааллыг судалснаар түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тогтоосноор эрчимт эмчилгээний сувилагчийн ажил үүргийг тодорхой болгож, ажлын бүтээмжийг сайжруулах ач холбогдолтой тул энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл боллоо.


Зорилго: Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн сувилагчийн сэтгэл ханамж, ажлын ачаалалыг судлахад оршино.

Зорилт:

1. Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нарын сэтгэл ханамжийг судлах
2. Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нарын ажлын ачаалалыг судлах


Хэрэглэгдэхүүн, арга аргачлал: Уг судалгааг 2020 оны 3 дугаар сарын 20-наас 2020 оны 3 дугаар сарын 25-ны хооронд Улсын хоёрдугаар төв эмнэлгийн Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн нийт 17 сувилагчаас асуумжын дагуу мэдээлэл цуглуулсан.

Үр дүн: Судалгаанд нийт 17 сувилагч хамрагдсан ба судалгаанд оролцогчдыг насны байдлаар нь ангилж үзвэл: 20-25 нас 23%, 26-30 нас 24%, 31-35 нас 18%, 36-с дээш нь 35% байна. (Зураг 1)




Зураг 1. Насны ангилал

Нийт судалгаанд оролцогчдын 82.3 хувь нь сувилагч мэргэжилдээ сэтгэл хангалуун байсан бол үлдсэн 17.6 хувь нь сувилагч мэргэжилдээ сэтгэл хангалуун бус байдаг нь тогтоогдсон. (Зураг 2)




Зураг 2. Сувилагч мэргэжилдээ сэтгэл хангалуун байдлыг судалсан дүн

Мэргэжлээ хэрхэн сонгосон байдлыг судлахад 47 хувь нь өөрийн хүсэлтээр, 41.1 хувь нь эцэг эхийн хүсэлтээр сонгосон бол үлдсэн 5.8 хувь нь бусад буюу найз нөхөд, хамаатан садны нөлөөлсөн байна. (Зураг 3)




Зураг 3. Мэргэжил сонголт

Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасагт ажилласан жилээр нь авч үзэхэд 1-4 жил 47%, 5-10 жил 17.6%, 11-с дээш 35.2% байна. (Зураг 4)




Зураг 4. Ажилласан жил

Эрчимт эмчилгээний сувилагч нарын ажлын ачааллын түвшинг тогтооход 88.2% ажлын ачаалал маш их, 11.7 хувь нь их байна. (Зураг 5)




Зураг 5. Ажлын ачаалаллын түвшинг судалсан дүн

Эрчимт эмчилгээний тасагт ажиллаж байгаа сувилагчийн хүрэлцээг тооцоход 100 хувь нь хангалтгүй гэж хариулсан байна. (Зураг 6)



Зураг 6. Сувилагчийн хүрэлцээ

Ажлын ачаалал үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлийг тогтооход судалгаанд оролцогчдын 24.7 хувь нь цахимд эм тарианы орлого, зарлага оруулах, эм тариа тараах үйлдлийг гүйцэтгэх, 17.6% хувь нь нэг сувилагчид ноогдох эмчлүүлэгчийн тоо стандартаас их, үүнээс шалтгаалан 23.7 хувь нь ажлын цагтаа тардаггүй, 19 хувь нь бичиг цаасны ажил хийхэд зарцуулдаг байна. (Зураг 7)



Зураг 7. Ажлын ачаалал үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйл

Хэлцэмж: Линда.Х. Икены судалгаанд "Сувилагчийн хариуцсан өвчтөний тоо нэгээр нэмэгдэхэд өвчтөний нас баралт 7%, сувилагчийн ажлын эрч хүч алдалт 23%, ажилдаа сэтгэл хангалуун бус байх байдал 15% нэмэгддэг" гэсэн судалгаа байдаг бөгөөд сувилахуйн хүний нөөцийг стандартаар ажиллах бололцоог хангаж ажиллах нь сувилагчийн ажлын ачааллыг тэнцүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Иймд эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нарын орон тоог нэмэгдүүлэх эсвэл сувилагчийн туслахын тоог нэмэх шаардлагатай байна.

Дүгнэлт:

1. Уг судалгаанаас үзэхэд сувилагч нарын ихэнх нь 1-4 жил ажилласан байгаа нь залуу хамт олон бүрдэж байгааг харуулж байна. Өөрийн сонирхлоор энэ мэргэжилээ сонгон мэргэжилдээ сэтгэл ханамжтай байгаа нь судалгаагаар харагдаж байна. MNS 6330:2017 стандартын дагуу эрчимт эмчилгээний сувилагчид 2 эмчлүүлэгч оногдох ёстой байдаг бол манай тасагт 1 сувилагчид 3-4 эмчлүүлэгч оногдож байгаа нь ажлын ачаалал их байгааг харуулж байна.
2. Сувилагч нар эм тариа тараах, түүнийг цахимд олгоход маш их цаг зарцуулж байгаа ба хөтлөгдөх бичиг баримтны ажил их байдаг учраас эмчлүүлэгчиддээ асаргаа сувилгааны тусламж үзүүлэх цаг бага байдаг. Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч нарын ажлын ачаалал маш их байдгаас сувилагч нар ажилдаа сэтгэл ханамж муу байна.

Талархал: Судалгаанд оролцсон Мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тасгийн нийт сувилагч нартаа талархал илэрхийлье.

Ном зүй:

1. *Эрчимт эмчилгээний үндэс 2013*
2. *MNS 6330:2017 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа*
3. *Stolberg SG. Patient deaths tied to lack of nurses. New York Times.August 8, 2002:A18.Google Scholar*
4. *Parker-Pope T. How to lessen impact of nursing shortage on your hospital stay. Wall Street Journal.March 2, 2001:B1.Google Scholar*
5. *Aiken LH, Clarke SP, Sloane DM. et al. Nurses' reports on hospital care in five countries. Health Aff (Millwood).2001;20:43-53. Google Scholar*

Results of a study of the workload of an intensive care nurse

M.Munkh-Erdene[1], B.Oyundari[1], P.Tungalag[1]

[1]Second State Central Hospital
E-mail: muugiimmuugim@gmail.com, Tel:88743245

Abstract: Nursing is a science that helps to maintain and improve a person's health and throughout life, from birth to death. That's why nursing has been around since the beginning of human. For example of this is a mother taking care of her child. The world is globalization the science of nursing care is an activity that has its own unique principles, rules and technology. During the Crimean War of 1850, nurse Florence Nightingale began to keep the most severe ill patients under supervision.

Then in 1923, Doctor Walter E opened a three-bed intensive care unit after neurosurgery and began to serve patients with a specially trained nurse, laying the foundation for the current Intensive Care Unit. The main goal of the intensive care unit is to bring together the patients with severe vital system disorders, to serve them with a skilled team using equipment and delicate diagnostic methods, to make a diagnosis in a short time and to treat and care in a timely manner. The survey was conducted from March 20, 2020 to March 25, 2020, according to a questionnaire from a total of 17 nurses in the Anesthesiology and Intensive Care Unit of the Second general hospital. The participants were classified by age: 23% between the ages of 20-25, 24% between the ages of 26-30, 18% between the ages of 31-35, and 35% over the age of 36. Satisfaction with the profession: yes 82.3%, no 17.6%. Depending on how they choose their profession: 47% at their own interest, 41.1% at the request of their parents, 5.8% under the influence of friends and relatives, and the other remaining 5.8%. By years of service in this department: 1-4 years 47%, 5-10 years 17.6%, more than 11 35.2%. In terms of workload: very high 88.2%, high 11.7%, medium 0%, low 0%. Sufficiency of nurses working in the ward: sufficient 0%, insufficient 100%. Difficulty working: 10.4% of nursing, 24.7% of /electronic/ drug delivery and distribution, 17.6% of patients per nurse, 23.7% of non-working hours, 19% of paperwork, poor work clothes 5 %. According to the survey, majority of the nurses have worked for 1-4 years, showing an increase in number of young colleagues. Research shows that people choose this profession based on their interests and are satisfied with their profession. According to the standard MNS 6330: 2017, intensive care nurses should serve 2 patients, while in our ward 1 nurse serves 3-4 patients, which shows that the workload is high. Nurses spend a lot of time distributing medicines electronically and doing paperwork that gives less time to provide care to their patients. The nurses of the intensive care unit are very overworked and they are dissatisfied with that.

Key words: Intensive care, Nursing, Workplace stress